



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/398

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангийн зээлийн
санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын “Дэмжлэг хүсэх тухай” 2014 оны 1а/3417 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Шопен ба XXI зууны Монгол” олон улсын төгөлдөр хуурийн тэмцээнд оролцож шилдэг оролцогчоор шалгарсан Хөгжим бүжгийн коллежийн оюутан Эрдэнэ овогтой Номинг Бүгд Найрамдах Польш Улсын Карло Земиановскийн нэрэмжит Хөгжмийн Академид төгөлдөр хуурийн чиглэлээр 2 жил, Монгол Улсад нэн хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэх зорилгоор Амгаланбаатар овогтой Мөнхбаатарыг Украин Улсын Кировоград хотын Үндэсний нисэхийн их сургуульд онгоцны нисгэгчийн мэргэжлээр 2 жил 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн Сургалтын Төрийн сангийн зээлийн санхүүжилтээр суралцуулсугай.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Б.Мөнхцэцэг/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР